

Б.Эрдэнэсүвд, эдийн засагч-хүн ам зүйч
МУИС, ХАССТ

Орхон аймагт шилжин ирэгчдийн шалтгаан, үр дагаварыг тодорхойлох судалгаа

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн амьдралд олон олон шинэ өөрчлөлтүүд гарсны нэг нь хүн амын байршил, шилжих хөдөлгөөний асуудал юм. Сүүлийн жилүүдэд Монголын хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрчимтэй нэмэгдэж буй нь шилжигчдийн уугуул нутаг болон шилжин ирж буй нутаг орнуудад эерэг талаасаа илүүтэйгээр нийгэм, эдийн засгийн олон бэрхшээл, хүндрэлтэй асуудлуудыг үүсгэж байна. 2000 онд НХХЯ-ны захиалгаар МУИС-ийн ХАССТ-өөс явуулсан “Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа” нь сүүлийн жилүүд дэх хүн амын шилжих хөдөлгөөний шинж байдал, шалтгаан, үр дагавар, чиг хандлага зэрэг хүн амын тооллогоос гаргах боломжгүй нарийвчилсан мэдээллийг гаргасан билээ.

Дээрх судалгаанд хүн амын механик өсөлт хамгийн өндөртөйд тооцогддог Орхон аймаг хамрагдаагүй учраас судлаач ажилдаа тус аймагт шилжин ирсэн 300 шилжигчийг хамруулан дээрх судалгааны аргачлалаар түүвэр судалгаа хийж, Дархан- Уул аймгийн шилжих хөдөлгөөний судалгааны үр дүнтэй харьцуулсны дээр шилжилттэй холбоотой аливаа сөрөг асуудлуудыг шийдвэрлэх талаар өөрийн дүгнэлт, зөвлөмжийг гаргажээ.

Үндэслэл

Хөдөө орон нутгаас хот суурин газар руу шилжих хөдөлгөөн нь тийм ч шинэлэг зүйл биш боловч сүүлийн жилүүдэд шилжих хөдөлгөөний урсгал улам бүр нэмэгдэж хүн амын тархалт байршилтад тэнцвэргүй байдлыг бий болгон улмаар улс орны тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж, төр засгийн анхаарлын төвд байх чухал асуудлын нэг болоод байна.

Шилжих хөдөлгөөн нь хүн амын өсөлт, хөгжлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд улс орны тогтвортой хөгжлийн олон чухал асуудлуудтай уялдаа холбоотой байдаг.

Дотоод шилжих хөдөлгөөний урсгал Монгол улсын томоохон суурингууд болох Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгууд руу, мөн үүний зэрэгцээгээр төмөр зам дагуух дэд бүтэц илүү хөгжсөн суурингууд руу чиглэсэн байна. Одоогийн байдлаар манай улсын хүн амын 57 хувь нь хот суурин газарт сууж байгаа бөгөөд хотын хүн амын жилийн дундаж өсөлт нь нийт хүн амын жилийн дундаж өсөлтөөс дээгүүр байна.

Төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөний түвшин, хандлагыг бүс нутгаар авч үзэхэд 400 мянга гаруй шилжигчид буюу нийт хүн амын 17 хувь нь төрснөөсөө хойш шилжих хөдөлгөөнд оролцжээ. Харин энэ үзүүлэлтийг Орхон аймгийн хувьд тооцож үзэхэд 70.4 хувьтай байлаа.

Орхон аймгийн шилжих хөдөлгөөний түүх

Орхон аймаг анх байгуулагдсанаас хойш эдүгээ 26 жилтэйгээ золгож байна. Орхон аймгийн хүн амын шилжих хөдөлгөөн нь нэлээд онцлогтой, байгуулагдсанаас нь хойш энэ шинэхэн суурин руу илгээлтийн эзэд ихээр шилжин ирэх болсон бөгөөд энэ нь олон жил хэвээр хадгалагдаж байсан.

Олон жилийн динамик мэдээллээс харахад хүн амын өсөлтөд механик өсөлт өндөр хувийг эзэлсээр байжээ. Орхон аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт 1979-1989 оны хооронд 13.54 буюу улсын хэмжээнд хамгийн өндөр байсан, энэ нь улсын дундаж өсөлтөөс 11 пунктээр өндөр байлаа. Харин 1989-2000 оны хооронд хүн амын жилийн дундаж өсөлт 2.23 байсан ба улсын дундаж өсөлтөөс 1.8 пунктээр өндөр байсан. 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнгээр, Орхон аймгийн суурин хүн ам 71525 гэж тоологдсон ба үүний 95.5 хувь нь хот суурин газартаа төвлөрдөг ажээ. Насны хувьд хүн амын ихэнх нь 10-44 насны бүлэгт төвлөрч байлаа.

15-аас дээш насны шилжин ирсэн хүн ам сүүлийн нэг жилийн хугацаанд 3342 байгаа нь Орхон аймагт шилжин ирэгчдийн тоо өндөр байгааг харуулж байна. 1999 оноос 2000 оны хоорондох хүн амын өсөлтийн хувь 5.8 хувь байхад үүний 79.3 хувийг механик өсөлт эзэлж байсан.

Шилжин ирэх урсгал нь харьцангуй тогтвортой болсон байснаа зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойшхи хугацаанд болон сүүлийн жилүүдийн дараалсан ган, зудын улмаас эргээд нэмэгдсэн байна. Орхон аймаг нь аж үйлдвэр, зах зээлийн томоохон суурин болсон төдийгүй дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн учраас шилжин ирэгчдийн тоо улам бүр нэмэгдэж байна. Засаг захиргааны шилжүүлэг хийлгэх төлбөрийн хэмжээг нэмэгдүүлсний улмаас бүртгэлгүй далд хэлбэрээр шилжигчдийн тоо нэмэгдлээ. 1989-2000 оны хооронд нэг хавтгай дөрвөлжин газар нутагт ногдох хүний тоо 66.8-аас 85.1 болж өссөн байна. Газар нутгийн хувьд бага учраас хүн амын нягтралаараа улсын дунджаас асар өндөр байна. Иймд хэрэв боломж байдаг бол Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуулинд өөрчлөлт оруулж Орхон аймгийн газар нутгийн хэмжээг өргөтгөхийн зэрэгцээ Хангайн бүсийн төв болгох нь хамгийн тохиромжтой гэж үзэж байна.

Тус аймагт шилжин ирэгчид нь ихэвчлэн зэргэлдээх аймгууд болон Баруун бүсийн аймгуудаас ирэгчид байдаг бол шилжин явагчдын ихэнхи нь Улаанбаатар хот болон Дархан-Уул аймгууд руу чиглэсэн урсгалтай байдаг.

Шилжих хөдөлгөөний талаарх мэдээллийн эх үүсвэрийг Хүн амын тооллогын мэдээнээс авч болох боловч тооллого нь шилжилтийн түүх болон шилжигчдийн шинж байдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгдөггүй. Мөн тооллогоор хүн амын шилжилтийн дараах сэтгэл хангалуун байдал, шилжигчид болон үлдсэн өрхийн гишүүд хоорондын эдийн засгийн харилцан холбоо, өрхийн эдийн засагт үзүүлж буй тусламжын хэлбэр зэрэг олон мэдээллийг авч чаддаггүй билээ. Иймээс тооллогоор гардаггүй дээрх нөхцөл байдлын талаарх мэдээллийг 2000 оны Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа (ХАССТ, 2000)-гаар гаргаж ирсэн. Энэ судалгаанд хүн амын механик өсөлт хамгийн өндөртэй аймаг

болох Орхон хамрагдаагүй учраас Орхон аймагт шилжин ирсэн хүн амын шилжилтийн үйл явц, шалтгаан, шилжих хүсэл сонирхол, шийдвэр гаргалт, шилжсэний дараах боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалт, тулгарч буй бэрхшээл зэрэг үзүүлэлтүүдийг судалсан юм. Судалгааг Засаг даргын Тамгын газартай хамтран явуулсан бөгөөд тус аймагт шилжин ирсэн 300 хүн хамрагдсан.

Судалгааны үр дүн

Судалгааны зорилго : Орхон аймагт шилжин ирэгчдийн шилжих хөдөлгөөнд оролцсон шалтгаан, үр дагавар, ирээдүйн хандлагыг бодитой тогтоож, шилжих хөдөлгөөнийг зохицуулах эдийн засаг, нийгэм, эрх зүйн үндсийг боловсруулахад ашиглах суурь материал бий болгоход оршино. Мөн түүнчлэн хотжилтын түвшингээрээ тус аймагтай ойролцоо түвшинд байдаг Дархан- Уул аймгийн шилжих хөдөлгөөний судалгааны үр дүнтэй харьцуулан шинжлэн, гүнзгийрүүлж судлахыг зорилоо.

Судалгааны ололттой тал : 1/ Орхон аймгийн шилжих хөдөлгөөний талаарх мэдээллийг зөвхөн иргэний бүртгэлийн мэдээллээс авдаг байсан бол шинэ мэдээллийн эх үүсвэртэй боллоо.


2/ Өмнө нь ижил төрлийн судалгаа явагдаж байсан учраас мэдээлэлд харьцуулалт хийн, дүн шинжилгээ өгөх боломжтой байсан.

Судалгааны дутагдалтай тал : Санхүүгийн байдлаас шалтгаалаад зөвхөн шилжих хөдөлгөөнд оролцсон 300 хүнээс судалгаа авсан. Энэ нь шилжих хөдөлгөөнд оролцсон болон оролцоогүй хүмүүсийн амьдралын нөхцөл байдлыг харьцуулах боломжгүй болгосон.

Судалгаанд хамрагдалт, шилжин ирэгчдийн ерөнхий шинж

Хүн амын нас, хүйсийн бүтэц нь шилжих хөдөлгөөний ялгавартай байдлыг бий болгодог. Судалгааны түүвэрлэлтэд Орхон аймагт шилжин ирсэн 300 хүнийг сонгосноос судалгаанд бүгд бүрэн хамрагдсан.

Зураг 1. Орхон аймагт шилжин ирэгчдийн нас, хүйсийн суварга




Орхон аймагт шилжин ирсэн хүн амын нас, хүйсийн суваргаас харахад(Зураг1), хүн амын ихэнх 20-44 насны бүлэгт төвлөрч байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд нь суралцах насандаа илүүтэйгээр шилжин ирсэн бол эрэгтэйчүүдийн дийлэнхи хувь нь 30-44 насны бүлэгт байна. Эндээс шилжих хөдөлгөөн нь насны болон хүйсийн хувьд ялгавартай байгааг харж болно.

Залуу насны хүн ам шилжих хөдөлгөөнд илүү оролцсон байгаа нь боловсрол эзэмших, ажил эрхлэх зорилгоор шилждэгтэй холбон тайлбарлагдаж болох юм. Учир нь шилжигчдийн шилжих хөдөлгөөнд оролцох болсон шалтгаанууд дотор ажил эрхлэх, боловсрол эзэмших шалтгаан нь бусад шалтгаануудаас өндөр хувьтай байгаа юм.

Шилжигчдийг боловсролын байдлаар авч үзэхэд, Орхон аймагт шилжин ирсэн дээд боловсролтой эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2 дахин өндөр байна. Үүнийг улсын хэмжээнд дээд боловсролыг эмэгтэйчүүд илүү эзэмших болсонтой холбон тайлбарлаж болно.

Зураг 2 : Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, боловсролын түвшин, хүйсээр



Мөн шилжин ирэгчдийн боловсролын түвшин нь Орхон аймгийн 7 ба түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшинтэй харьцуулахад өндөр байсан. 2000 онд явагдсан судалгааны Дархан-Уул аймагт шилжин ирэгчдийн боловсролын түвшинтэй харьцуулахад нэлээд ойролцоо байгаа боловч бага боловсролтой болон боловсролгүй хүн амын эзлэх хувь нь маш доогуур байна.

Шилжих хөдөлгөөний татах, түлхэх хүчин зүйлс :

Тухайн хүн шилжих хөдөлгөөнд оролцох эсэх нь тэдний уугуул нутгийн амьдралын нөхцөл байдлыг илэрхийлсэн түлхэх хүчин зүйлс, шилжин суурьшсан газар нутгийн тааламжтай байдал буюу татах хүчин зүйлсээс ихээхэн шалтгаалдаг болохыг судлаачид тогтоожээ. (ХАЗССТ, 2000)

Орхон аймгийн хувьд уугуул нутгуудтай харьцуулахад татах хүчин зүйлс илүүтэй байгаа. Үүнд зах зээл, худалдан авах болон худалдаалах боломж өндөр, дэд бүтэц сайн хөгжсөн, ажлын байр харьцангуй элбэг, хувь

өөрийгөө хөгжүүлэх сурч боловсрох орчин бүрдсэн, нийгэм соёлын үйлчилгээ сайн гэх мэт. Харин сүүлийн жилүүдэд хэт төвлөрөл болон аж үйлдвэржилтээс болж агаарын болон орчны бохирдол ихсэж байгаа нь түлхэх хүчин зүйл болж байна. Уугуул нутгуудын буюу хөдөө орон нутгуудын хувьд худалдаа наймаа эрхлэх боломж тааруу, сурч боловсрох нөхцөл сайнгүйн дээр амьдралын нөхцөл байдал хэцүү, дэд бүтэц, харилцаа холбоо сайн хөгжөөгүй, зуд болж малаа алдах гэх мэт олон түлхэх хүчин зүйлстэй байдаг ч эрүүл экологийн нөхцөл байдал нь татах хүчин зүйл болж байдаг ажээ.

Шилжих хөдөлгөөний сүлжээ, шийдвэр гаргалт :

Судалгаагаар шилжин ирэгчдийн өмнө нь амьдран сууж байсан газар, шилжилтэд оролцохоосоо өмнө шилжин суурьсан нутгийн талаар мэддэг байсан эсэх, энэ тухай мэдээллийг ямар эх үүсвэрээс олж авсан болон тухайн газар нутагт оршин суудаг хүмүүсээс шилжин ирэгчидтэй ямар төрлийн холбоо хамааралтай байсан зэрэг шилжих хөдөлгөөний харилцан холбоог илэрхийлэх хэд хэдэн асуултуудыг асуусан. Энэ харилцан холбоо буюу сүлжээ нь хүн амыг шилжих хөдөлгөөнд татан оролцуулах гол хүчин зүйлсийн нэг юм.

Шилжин ирэгчдийн дийлэнхи хувь нь төвийн болон баруун бүсийн аймгуудаас байгаа бөгөөд хүйсийн хувьд нэлээд ялгаатай байгаа нь харагдаж байлаа. Ерөнхийдөө бүс хоорондын шилжих хөдөлгөөн өндөр байгаа ч Увс, Завхан, Булган, Хөвсгөл аймгуудаас Орхон аймаг руу чиглэсэн урсгал хамгийн өндөр байна. Харин говийн болон зүүн бүсээс шилжин ирэх нь бага байлаа. Тус аймагт шилжин ирэгчдийн дотор өмнө нь Орхон аймагт амьдарч байсан эрэгтэйчүүд 5.3, эмэгтэйчүүд 8.1 хувийг эзэлж байгаа нь буцах шилжих хөдөлгөөн тодорхой хэмжээгээр байгааг харуулж байна. Дархан-Уул аймгийн хувьд буцах шилжих хөдөлгөөн хамгийн өндөр буюу 23 хувьтай байсан. Өмнө нь сууж байсан газрын байршлаар нь авч үзэхэд дийлэнхи хувь нь аймгийн төв болон сумын төвөөс байна. Аймаг, сумын төвөөс шилжин ирэгчдийн дийлэнх нь малгүй байдаг учраас хөдөөгийн хүмүүсийг бодвол хот, суурин газарт шилжин суурьшихад хялбар байдаг байж болох юм. Мөн түүнчлэн ажлын байр дээрх газруудад ховор байдгаас шалтгаалан гадагшаа чиглэсэн шилжилт их байдаг болов уу.

Орхонд шилжин ирэгчдийн шилжих шийдвэрээ хэрхэн гаргасан байдлыг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1 : Шилжих хөдөлгөөнд оролцогчдын шилжих шийдвэр гаргалт, хүйсээр

Шийдвэр гаргалт	Хүйс	
	Эрэгтэй (%)	Эмэгтэй(%)
Зөвхөн өөрөө	51.0	22.1
Өөрөө бусадтай хамт	49.0	77.9
Бүгд	100	100
Тоо	151	149

Судалгааны энэ хэсгийн үзүүлэлт өмнөх судалгаатай харьцуулахад мөн ойролцоо үр дүнтэй байсан. Жишээлбэл өмнөх судалгаагаар Дархан-Уул

аймагт шилжин ирсэн эрэгтэйчүүдийн 49.6 хувь нь, эмэгтэйчүүдийн 23.5 хувь нь өөрөө шилжин ирэх шийдвэрээ гаргасан байна.

Эрэгтэй шилжин ирэгчид шилжих хөдөлгөөнд оролцохоо бусдын оролцоогүйгээр өөрсдөө шийдсэн байхад эмэгтэйчүүдийн хувьд бага хувьтай байна.

Ганцаарчилсан болон гэр бүлийн шилжилт :

Тантай хамт хүмүүс шилжин ирсэн үү? гэсэн асуултанд хариулгчдын 75 хувь нь тийм гэж хариулсан ба ихэнхи нь гэр бүлийн гишүүд болон эцэг эхтэйгээ хамт ирсэн байна. Энэ нь Монголд гэр бүлийн шилжилт зонхилдог гэдгийг давхар баталлаа. Харин таныг шилжиж ирсэний дараа, араас тань хүмүүс ирсэн үү гэсэн асуултанд 24 хувь нь тийм гэж хариулсан ба үүний ихэнхи хувь нь бусад хамаатан садан байсан. Эндээс, шилжигчид эхлээд шилжиж ирэхдээ гэр бүлийн гишүүдтэйгээ хамт ирдэг бөгөөд араасаа хамаатан садангаа татдаг нь харагдлаа.

Шилжин ирэгчдийн араас ирээдүйд дахин хүн ирэх эсэх талаар асуухад тийм гэж хариулсан хувь өмнөх судалгааг бодвол арай илүү өндөр хувьтай байлаа. Өрхөд араас нь шилжин ирэх хүмүүсийн дундаж тоо ойролцоогоор 2-3 байна. Хүйсийн хувьд онцын ялгаа байхгүй байгаа боловч Орхон, Дархан-Уул аймгуудын аль алинд шилжин ирсэн эрэгтэйчүүдийн араас ирэх хүмүүсийн тоо эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаа нь ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл шилжин ирэгч эмэгтэйчүүд маань араасаа эрэгтэйчүүдийг бодвол бага хүн дагуулдаг бололтой. Эцэг эх, хамаатан саднаа авчирна гэсэн хүмүүсийн хувь өндөр байна. Энэ мэдээллээс ч шилжин ирэгчид гэр бүлийн шилжилт хийсэн гэдэг нь харагдаж байна. Ирээдүйд шилжин ирэх гэж буй хүмүүсийн 90 гаруй хувь нь байнга оршин суухаар ирнэ гэж хариулжээ. Эндээс үндэслэн дүгнэвэл Орхон аймаг руу чиглэсэн урсгал ирээдүйд ч өндөр байх төлөвтэй. Ирээдүйд оршин суухаар ирэх хүмүүсийн эзлэх хувийг Дархан-Уултай харьцуулбал, Орхон аймагт эрэгтэй 6.0, эмэгтэй 4.3 пунктээр тус тус өндөр байна.

Шилжилтийн шалтгаан :

Шилжих хөдөлгөөнд оролцсон шалтгааныг судлах нь уугуул нутгийн түлхэх хүчин зүйлс болон шилжин суурьшсан нутгийн татах хүчин зүйлсийг судлах, ингэснээр хүн амын суурьшлын зохисой бүтцийг бүрдүүлэх, төрийн бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой билээ. Иймээс судалгаанд шилжих болсон шалтгааныг чухалчлан авч үзсэн юм. Эдгээрийг 2 аймгаар харьцуулан үзүүлбэл,

Шалтгааны эрэмбэ:	Орхон аймагт шилжин ирсэн шалтгаан	Дархан-Уул аймагт шилжин ирсэн шалтгаан
1	Ажиллах	Төрөл саднаа бараадах
2	Зах зээлд ойртох	Амьдралын нөхцлөө сайжруулах
3	Төрөл саднаа бараадах	Зах зээлд ойртох
4	Хүүдүүдийнхээ ирээдүйг бодож	Ажиллах
5	Амьдралын нөхцлөө сайжруулах	Хүүдүүдийнхээ ирээдүйг бодож
6	Нийгэм оюуны хэрэгцээгээ илүүтэйгээр хангах	Суралцах
7	Суралцах	

Шилжин суурьшсан нутгууд дахь шилжих хөдөлгөөний үр дагавар, зохицуулалт :

Шилжин суурьшсан нутаг дахь шилжин ирсэн хүн амд тохиолдсон гол бэрхшээл, тэдгээрийг даван туулахын тулд тусламж эрсэн байдал, үзүүлсэн тусламжын хэлбэрүүдийг нарийвчлан тодорхойлохыг зорилоо. Ингэснээр шилжин ирэгчдэд чиглэсэн арга хэмжээг боловсруулахад дөхөмтэй. Шилжин ирсэн хүн амын амьжиргааны гол эх үүсвэр болсон ажил эрхлэлт хэрхэн шийдэгдэж байгаа болон амьжиргааны түвшинд ямар өөрчлөлт орж байгаа, манай улсад хэрэгжиж байгаа гадаад дотоодын төсөл хөтөлбөрүүд хэр жигд хүртээмжтэй байгаа зэргийг авч үзэв. Түүнчлэн хүн ам эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд Засгийн газраас ямар арга хэмжээ авах нь зөв гэж үзэж байгааг нь давхар асуусан юм.

Мөн энэ хэсэгт, шилжих хөдөлгөөний ирээдүйн төлөв байдлыг тодорхойлох зорилгоор шилжин ирэгчдийн шилжих хөдөлгөөний ирээдүйн хандлагыг шалтгаанаар авч судалсан.

Шилжилтийн дараа тулгарч буй бэрхшээлүүд :

Орхон аймагт шилжин ирэгчдийн 43 хувь нь шилжин ирсний дараа бэрхшээл тулгарсан гэж хариулсан байна. Хамгийн их тулгарсан бэрхшээлийг Дархан-Уултай харьцуулбал,

эрэмбэ	Орхон	Дархан-уул
1	Ажил олдохгүй	Ажил олдохгүй
2	Орон сууцны	Орлогын эх үүсвэргүй
3	Засаг захиргааны шилжүүлэггүй	Орон сууцны
4	Орлогын эх үүсвэргүй	Бэлчээрийн асуудал
5	Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй	Газрын зөвшөөрөл олдохгүй
6	Нутаг оронд дасахгүй	Нутаг оронд дасахгүй

Орхон аймагт шилжин ирэгчдэд бэрхшээл их тулгардаг юм байна. Хүйсийн ялгавартай байдлаар авч үзвэл эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдийг бодоход илүү бэрхшээл тулгарчээ. Ялангуяа эрүүл мэндийн үйлчилгээнд эрэгтэйчүүд бага хамрагддаг ба ажил олдохгүй байгаа нь нийгэм, эдийн засгийн тулгамдсан нийтлэг бэрхшээлтэй асуудал болж байна.

Шилжин ирэхэд ямар нэгэн бэрхшээл тулгарсан гэсэн хариулагчаас туслалцаа авсан байдлыг нь сонирхсон бөгөөд энэ нь Орхон аймагт шилжин ирэгчдэд өндөр хувьтай байсан бөгөөд чухам ямар туслалцаа авсныг нь тодруулахад *нэгдүгээрт*, мөнгөн туслалцаа, *хоёрдугаарт*, ажил олоход тусалсан, *гуравдугаарт*, мөнгөөр тусалсан нь тусламжын бусад хэлбэрүүдээс дээгүүр байна. Сэтгэл санаагаар дэмжсэн байдал өндөр байгаа ч Орхон аймагт мөнгөн болон материаллаг тусламж авсан хүний эзлэх хувийн жин харьцангуй өндөр байна. Мөн түүнчлэн ямар ч туслалцаа аваагүй хүмүүсийн эзлэх хувь доогуур байгаа нь харагдлаа. Энэ нь Орхон аймагт шилжин ирэгчдийг татах нэг хүчин зүйл байж болох юм.

Шилжих хөдөлгөөн ба ажил эрхлэлт :

Хүснэгт 2 : Шилжиж ирсний дараах ажил эрхлэлтийн байдал, хүйсээр

Шилжиж ирснээс хойш ажил хийсэн эсэх	Орхон		Дархан-Уул	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Тийм	57.0	52.3	70.3	60.1
Үгүй	43.0	47.7	29.7	39.9
Бүгд	100	100	100	100
Тоо	151	149	236	281

Шилжсэний дараах анхны ажил эрхлэлтийн түвшинг Дархан-Уул аймгийн 2000 оны мөн үзүүлэлттэй харьцуулахад нэлээд доогуур байна. Гэхдээ ажил эрхэлж байгаа хүмүүсийн эзлэх хувь 50-аас илүү байгаа нь ажиллах хүчний шингээлт сайтайг харууллаа. Ажил эрхлэлтийн түвшинг хүйсээр задалж үзэхэд эрэгтэйчүүдийн ажил эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс өндөр байна. Байгаа ажлын байр нь голдуу эрэгтэй хүмүүс хийхэд тохиромжтой хүнд хүчир ажил байдаг юм болов уу. Мөн Орхон аймагт шилжин ирэгчдийн нэлээд хувь нь төрийн төсвийн байгууллагад ажилд орсон байгаа бөгөөд энэ нь шилжин ирсэн хүн амын боловсролын түвшин өндөр байсантай холбоотой.

Ажил эрхлэхгүй байгаа шалтгааныг авч үзвэл,

эрэмбэ Орхон

- 1 Ажил олдохгүй
- 2 Гэрийн ажилтай
- 3 Тэтгэвэрт
- 4 Суралцдаг

Дархан-Уул

- 1 Ажил олдохгүй
- 2 Хүсээгүй/шаардлагагүй
- 3 Тэтгэвэрт
- 4 Эрүүл мэндийн байдлаас

Ажил хайгаад олдохгүй байгаа нь судалгаанд хамрагдсан нийт хүн амын ажил эрхлэхгүй байгаа томоохон шалтгаан болж байгааг дээрх баримтаас харж болно. Хүйсийн хувьд хүүхэд, өндөр настан асрах хүнгүй байгаагаас ажил эрхлэхгүй байгаа эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс нэлээд их байсан. Ажиллахыг хүсээгүй, шаардлагагүй хүмүүсийн эзлэх хувь маш бага байгаа нь амьжиргааны түвшин доогууртай хүмүүс шилжих хөдөлгөөнд ихээр оролцсон байж болохыг харуулж байна.

Шилжих хөдөлгөөний үр дагавар :

Шилжин ирсний дараа шилжин ирэгчдийн ахуй амьдралд ямар нэгэн өөрчлөлт гарсан эсэхийг судалгаагаар асууж судалсан.

Эрхэлдэг ажил : Шилжин ирсний дараа ажлын байр сайжирсан гэж хариулсан эрэгтэйчүүдийн хувь Дархан-Уул аймагт Орхон аймгийнхаас илүү өндөр байна. Ихэнхи хувь нь өөрчлөлт ороогүй гэж үзжээ. Судалгаанд хамрагдсан газруудад шилжсэний дараа ажил төрөл доройтсон гэж шилжин ирэгчдийн 10-13 хувь нь хариулжээ.

Орлого : Орхон аймагт шилжин ирэгчдийн дийлэнх хувь нь орлого хэвээрээ байна гэж үзжээ. Дархан-Уул аймгийн хувьд мөн л эрэгтэйчүүдийн орлого


нэмэгдсэн хувь нь өндөр байна. Орлого доройтсон гэж хариулагчдын хувь харьцангуй бага байгаа нь эерэг үзүүлэлт юм

Боловсрол болон мэргэжлийн чадвар : Боловсрол болон мэргэжлийн чадвар сайжирсан гэж үзсэн эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийнхээс илүү өндөр байна.

Хүүхдүүдийн сургалт : Орхон аймагт шилжин ирсэн эмэгтэйчүүдийн 38 хувь нь хүүхдүүдийн сургалт сайжирсан гэж үзсэн байхад эрэгтэйчүүдийн 23 хувь нь дордсон гэсэн байна. 2000 оны судалгаагаар хүүхдүүдийн боловсролын түвшин сайжирсан гэж үзсэн шилжин ирэгчдийн хувь Улаанбаатарт хамгийн өндөр байсан бөгөөд энэ нь хүүхдийн боловсролын асуудалд шилжих хөдөлгөөний баршил онцгой ач холбогдолтойг харуулж байна.

Орон сууцны нөхцөл байдал : Орон сууцны нөхцөл байдал сайжирсан гэж үзсэн шилжин ирэгчдийн хувь өндөр байгаа хэдий ч өөрчлөгдөөгүй гэж үзсэн хариулагчдын эзлэх хувийн жин хамгийн өндөр байна. Энэ нь орон сууцны хангамж бага, үнэ нь өндөр байдагтай холбоотой.

Зураг 4 : Хүүхэдтэй шилжих хөдөлгөөнд оролцсон хариулагчдын хүүхдийн боловсрол эзэмших боломж



Эрүүл мэнд : Эрүүл мэндийн нөхцөл байдал сайжирсан гэсэн хариулагчдын хувь Дархан-Уул аймагтай харьцуулахад өндөр байна.

Нийтийн унаа : Орхон аймагт шилжин ирэгчдийн ихэнхи хувь нь нийтийн унааны асуудал сайжирсан гэж үнэлжээ. Энэ үзүүлэлтийг Дархан-Уул аймагтай харьцуулахад нэлээд өндөр байна. Дэд бүтцийн хөгжлийн түвшин хот хөдөөд хэтэрхий ялгаатай байгааг энэ үзүүлэлт харууллаа.

Зах зээл, худалдан авах, худалдаалах боломж : Шилжин ирэгчдийн нэлээд хувь нь зах зээл, худалдан авах ба худалдаалах боломж нэмэгдсэн гэж үзсэн байна. Энэ үзүүлэлт Орхон аймгийн хувьд илүү өндөр байлаа. Харин Дархан-Уул аймагт шилжин ирэгчдийн нэлээд хувь нь буюу 17-19 хувь нь зах зээл, худалдан авах ба худалдаалах боломж дордсон гэж үзсэн байна.

Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалт :

Орхон аймгийн хувьд шилжин ирэгчдийн ихэнхи хувь нь сумын эмнэлэгт үзүүлдэг байхад Дархан-Уул аймагт шилжин ирэгчдийн ихэнхи нь сумын эмнэлэгт үзүүлдэг байна. Түргэн тусламж болон хувийн эмнэлэгт үзүүлэгчдийн хувь Орхон аймагт Дархан-Уул аймгаас өндөр байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүд эрүүл мэндийн үйлчилгээг илүү хүртэж чаджээ. Энэ нь нэг талаас эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдээс илүү эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагатай байдаг, нөгөө талаас эрүүл мэнддээ илүү анхаарч ямар нэг үйлчилгээнд хамрагдаж чадаж байгааг харуулж байж болох юм.


Боловсрол эзэмших боломж :

Шилжин ирэгчдийн хүүхдэд боловсрол эзэмших боломж Дархан-Уул аймагт арай дээгүүр байна. Хүүхэдтэй шилжин ирэгчид болон шилжих хөдөлгөөнд оролцсон хариулагчаас хүүхдүүддээ боловсрол эзэмших боломж байхгүй гэж хариулсан хүмүүсээс шалтгааныг тодруулан асуусан. Шилжих хөдөлгөөнд оролцсон, хүүхэдтэй хүмүүсийн хүүхдэд боловсрол эзэмших боломж байхгүй байгаа шалтгааныг авч үзэхэд, эдийн засгийн (87.1%), бүртгэлгүй (3.2%), сургууль нь дотуур байр байхгүй (9.7%) гэсэн шалтгаанууд зонхилж байв. Энэ нь их дээд сургуулиудын төлбөр учраас тэдэнд хүүхдээ сургах боломжгүйг харуулж байна. Мөн бүртгэлгүй шилжигчдийн хувьд хүүхэд нь боловсрол эзэмших асуудал их хүндрэлтэй байдаг. Учир нь шилжүүлэг хийлгэх төлбөр өндөр гэж шилжигчид үздэг байна.

Засгийн газар болон Олон нийтийн байгууллагын тусламж :

Эрэгтэйчүүдийн 62.9 хувь, эмэгтэйчүүдийн 71.1 хувь нь манай улсад хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрүүдээс аль нэгийг нь мэддэг юм байна.

Зураг 5 : Төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдлэг, хүйсээр



Дээрх төсөл хөтөлбөрүүдээс ногоон хувьсгал болон вакцинжуулалтыг судалгаанд хамрагдагсад хамгийн их мэддэг юм байна. Хүйсийн хувьд эмэгтэйчүүдийн мэдлэг харьцангуй өндөр байсан. Ямар ч төсөл, хөтөлбөр мэдэхгүй хариулагчдын хувь 2000 оны судалгааны тус үзүүлэлттэй харьцуулахад Орхон аймагт нэлээд өндөр байлаа. Судалгаанд хамрагдсан хариулагчид манайд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг жигд мэддэг боловч тэдгээр төслүүдэд хамрагдаж үр өгөөжөөс нь хүртсэн байдал эрс ялгаатай байна.

Судалгаанд хамрагдсан нийт эрэгтэйчүүдийн 38.4 хувь нь эдгээр төсөл хөтөлбөрүүдийн ядаж нэгнээс нь хүртсэн бол эмэгтэйчүүдийн 48.3 хувь нь хүртсэн байна.

Нийт хариулагчдын хувьд үр шимийг нь хамгийн их хүртсэн төсөл нь вакцинжуулалт (эмэгтэйчүүдийн хувьд 65.3 хувь, эрэгтэйчүүдийн хувьд 37.9 хувь) байна. Мөн эрэгтэйчүүд ногоон хувьсгал хөтөлбөрт илүүтэйгээр хамрагдсан байлаа. Эдгээр хөтөлбөрүүдэд шилжин ирэгчдийг илүү их хамруулах шаардлагатай байна.

Ирээдүйн шилжилт :

Хүснэгт 3 : Шилжин ирэгчдийн ирээдүйн шилжилт, хүйсээр

Одоогийн байгаа газраасаа шилжихийг хүсч байгаа эсэх	Орхон	
	Эрэгтэй	Эмэгтэй
Тийм	9.3	12.1
Үгүй	90.7	87.9
Бүгд	100	100
Тоо	151	149

Орхон аймагт шилжин ирэгчдийн шилжих хөдөлгөөний цаашдын хандлага ямар байхыг судалж үзэх үүднээс судалгаанд энэ сэдвийг хамруулсан. Дээрх хүснэгтээс харахад шилжин ирэгч эрэгтэйчүүдийн дийлэнх хувь нь ирээдүйд шилжихийг хүсэхгүй байна. Энэ нь Орхон аймагт татах хүчин зүйл их байгааг харуулж байна. Гэхдээ энэ байдлаараа шилжих хөдөлгөөн их байхын зэрэгцээ ирээдүйд буцан шилжих сонирхол байхгүй байх нь Орхон аймгийн агаарын бохирдлыг ихэсгээд зогсохгүй хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлдэг. Ингээд шилжихийг хүсэхгүй байгаа шалтгааныг тодруулахад, утаг орондоо дасан зохицсон, амьдрал төвхнөсөн/дээшилсэн, ах дүү, төрөл садан бөөгнөрсөн, эдийн засгийн боломжгүй зэрэг шалтгаанууд зонхилж байна. Ирээдүйд Орхон аймгаас шилжихийг хүсч байгаа шалтгааныг нь тодруулахад, ажиллах, амьдралын нөхцлөө сайжруулах, экологийн нөхцөл, суралцах гэсэн шалтгаанууд зонхилж байна.

Эцэст нь дүгнэхэд, Орхон аймагт суурьшиж байгаа шилжин ирэгчид болон шилжих хөдөлгөөнд оролцоогүй хариулагчид ихэнх хувь нь одоогийн байгаа газартаа сэтгэл хангалуун байгаа бөгөөд бага хэсэг нь ирээдүйд эдийн засгийн, амьдралын нөхцлөө сайжруулах гэсэн шалтгаанаар шилжихийг хүсч байна.

Орхон аймагт шилжин ирэгчид өөрсөддөө тулгарч буй бэрхшээлээс үүдэн, дараах арга хэмжээнүүдийг засгийн газраас аваасай гэж хүсч байна. Үүнд: Шилжих хөдөлгөөнийг чөлөөтэй байлгах, бүртгэлийн шат дамжлагыг цөөрүүлэх, ажлын байрыг хүртээмжтэй байлгах, орон сууцаар хангах, боловсрол, Эрүүл мэндийн салбарт анхаарах зэрэг байна.

Дүгнэлт, Зөвлөмж

Энэхүү судалгаагаар Орхон аймагт шилжин ирсэн хүн амын шилжилтийн үйл явц, шалтгаан, шилжих хүсэл сонирхол, шийдвэр гаргалт, шилжсэний дараах боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалт, тулгарч буй бэрхшээл зэрэг үзүүлэлтүүдийг судалсан юм.

Судалгааны дүнгээр шилжин ирэгчдийн ихэнх хувь нь залуучууд, боловсролын түвшин харьцангуй өндөртэй хүмүүс байна. Шилжилтийн хэлбэрийн хувьд гэр бүлийн шилжилт давамгайлж байлаа. Шилжин ирэгчдийн дийлэнх хувь нь баруун болон төвийн бүсийн аймгуудаас шилжин ирсэн ба ирээдүйд шилжих хүсэлтэй байгаа хүн амын олонх нь нийслэл рүү шилжих хүсэлтэй байна.

Шилжин ирэгчид ихэвчлэн ажил эрхлэх, зах зээлд ойртох, амьдралын нөхцөл байдлаа дээшлүүлэх, үр хүүхдийнхээ ирээдүйг бодох, төрөл саднаа бараадах, нийгэм оюуны хэрэгцээгээ илүүтэйгээр хангах шалтгааны улмаас шилжилтэнд оролцжээ. Ирээдүйд шилжихийг хүсч буй хүн амын хувьд ч эдгээр шалтгаан өндөр хувийг эзэлж байгаа юм. Шилжин ирсэн хүн амын 90-ээд хувь нь ирээдүйд ахин шилжихийг хүсээгүй байна.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувьд шилжилттэй холбогдон гарч байгаа бэрхшээлүүдийг даван туулах, хүмүүсийн тогтвор суурьшилтай амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн тулд засгийн газраас шилжих хөдөлгөөнийг чөлөөтэй байлгах, бүс нутгийн хөгжилд анхаарах, ажил эрхлэлт, амьдралын нөхцлийг сайжруулах асуудлуудад хамгийн их анхаарч, арга хэмжээ аваасай гэж хүсчээ.

Шилжин ирэгчдийн шилжин ирсэнээс хойшхи эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдалтын түвшин муу, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хангамж хангалтгүй байсан байна.

Хөдөөгийн болон бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийн хүрээнд хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн, урсгалаас урьдчилан сэргийлж хөдөөд хүн амын тогтвор суурьшилтай амьдралыг бий болгох, харин нэгэнт шилжсэн хүн амын хувьд хот төлөвлөлт, нийгмийн халамж үйлчилгээний асуудлын хүрээнд шилжигчдэд тусламж дэмжлэг үзүүлэх зорилго бүхий шилжих хөдөлгөөний цогц бодлого боловсруулах шаардлагатай байна.

УИХ-аас батлан гаргасан бүс нутгийн ангиллаар Орхон аймаг хангайн бүсэд хамрагдсан бөгөөд тус бүсийн төв болох хамгийн тохиромжтой аймаг юм. Иймээс газар нутгийн асуудал дээр анхаарах хэрэгтэй болов уу.

Судалгааны үр дүнгээс үндэслэн дараах бодлогын чанартай санал, зөвлөмжүүдийг гаргаж байна. Үүнд :

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг өргөжүүлэх, малжуулах төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, малчдын хувьд зах зээлээс хол байдгийг харгалзан мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэгцээт газарт нь нийлүүлж тэдний өргөн хэрэглээний барааг бэлтгэн нийлүүлдэг арга механизм бүрдүүлэх, төвөөс алслагдсан байдлыг харгалзан эдийн засгийн хөнгөлөлттэй арга хэмжээг авах (ХАЗССТ, 2000)
- Аймгийнхаа хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлохдоо ирээдүйн шилжих хөдөлгөөний түвшинг тодорхойлон, тусгах хэрэгтэй.
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэлт, хоршооллыг дэмжих, өрхийн аж ахуйг хөгжүүлэх замаар хөдөө орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх
- Орхон аймгийг хангайн бүсийн төв болгосноор Их, дээд сургуулиудын салбарыг шинээр бий болгон боловсрол соёлын төв болгох
- Хөдөөд хүний нөөцийг тогтвортой тараан байршуулах, үүний тулд шинээр төгссөн боловсон хүчнүүдээ орон нутагт нь эргэн татах, хөдөөд амьдрах боломж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх

- Шилжин ирэгчдийг засгийн газраас болон олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдээс хүртэх боломжоор хангах
- Нэгэнт шилжээд ирсэн хүмүүсийн хүний эрхийн асуудлыг хөндөхгүй байх тэдэнд зөвлөгөө өгдөг төвийг нээн хүрч ажиллах, бүс нутгийн хооронд Хөдөлмөр эрхлэлтийн албаны талаар мэдээллийн сүлжээтэй болгох
- МАА-н салбарыг эрчимжүүлэх ,малын чанарын асуудалд одооноос эхлэн анхаарч айл өрхөөр хоршсон фермерийн аж ахуйг бий болгох